



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

### Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 7 дугаар хэсгийн 7.7.3, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 08/52 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн гэмт хэрэг зөрчил ихээр бүртгэгддэг, иргэд оршин суугчдаас удаа дараа гомдол санал ирсэн, галын аюулгүй байдлын болон эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байсан Хангарьд хангал ХХК-ний “Фокус”, иргэн Т.Энэбишийн “Од”, иргэн Х.Болормаагийн “Тайга”, иргэн Д.Наранзулын “Зүүм” дэн буудлуудын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Хүчин болгосон зөвшөөрлийг хураан авч Нийслэлийн Цагдаагийн газарт мэдээллийг хүргүүлэхийг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batsum* Д.БАТСҮХ



1150500029